

ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН БАНК ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 07 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар 03

Эхэлсэн цаг: 10 цаг 00 минут
Дууссан цаг: 11 цаг 37 минут

Худалдаа, хөгжлийн банкны хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн ээлжит бус хурал (цаашид “ХЭХ” гэх) Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 2 дугаар хороо, Ерөнхий сайд Амарын гудамжинд байрлах Бэст Вестерн Премьер буудлын “Соёмбо” танхимд 10 цаг 00 минутад эхэлж, 11 цаг 37 минутад дуусав.

Хөтлөгч О.Баярсайхан: Сайн байцгаана уу? Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Худалдаа, хөгжлийн банк анхдагч зах зээлд амжилттай IPO хийсэнтэй холбогдуулан Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-өөс нээлттэй хувьцаат компани хэлбэртэй Худалдаа, хөгжлийн банкны анхны хувьцаа эзэмшигчдийн хурлыг 2023 оны 7 сарын 7-ны өдөр хуралдуулахаар зарласан тул та бүхэнтэй энэхүү цаг мөчид танхимаар болон цахимаар уулзаж байна. Ингээд хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга ноён Рандолф Коппа таныг хурлыг нээнэ үү хэмээн урьж байна.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга Рандолф Коппа: Өглөөний мэнд, эрхэм хувьцаа эзэмшигч, хамтран ажиллагч, ноёд хатагтай нараа та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтган мэндчилж байна. Худалдаа, хөгжлийн банк нь 2023 оны 5 дугаар сард хувьцаагаа олон нийтэд санал болгосон билээ. 2023 оны 5 дугаар сард 5%-ийн хувьцаагаа олон нийтэд санал болгон IPO-г амжилттай хийж олон нийтэд нээлттэй хувьцаат компани болсноор манай банкны түүхэн шинэ хуудас эхэлж байна. Худалдаа, хөгжлийн банк хувьцаат компанийн анхны хувьцаа эзэмшигчдийн хурлыг өнөөдөр хийж байгаадаа маш их баяртай байна. Та бүхэндээ баяр хүргэе.

Бидэнд итгэж хөрөнгө оруулсан хувьцаа эзэмшигч та бүхэндээ дахин талархал илэрхийлье. Монголын хөрөнгийн бирж дээр хоёрдогч зах зээлийн арилжаа нээгдсэнээс хойш ч мөн Худалдаа, хөгжлийн банкны хувьцаа гүйцэтгэл сайтай байж, Монголын хөрөнгийн биржийн идэвхитэй арилжаалагддаг үнэ цэнтэй хувьцаануудын нэг болсон байна. Бидний дунд, урт хугацааны зорилтууд, стратегийн чиглэлүүд, төлөвлөж буй, хийж буй ажлууд амжилттай хэрэгжиж, компанийн үнэ цэн цаашид улам нэмэгдэнэ гэдэгт итгэл төгс байна. Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөл, удирдлагын баг болон ажилтнууд хичээн ажиллаж байна.

[Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга Рандолф Коппагийн ХЭХ дээр хэлсэн үгийг хөтлөгч О.Баярсайхан орчуулав.]

[Тооллогын комисс ХЭХ-ын ирцийн мэдээг дэлгэцэнд танилцуулав.]

Санал өгсөн хэлбэр	Саналын эрхтэй хувьцааны хувь
Саналын хуудсаар урьдчилан өгсөн санал	90.49%
Зайнаас буюу цахимаар оролцож байгаа	0.02%
Танхимаар оролцож байгаа	0.006%
Нийт саналын эрхтэй хувьцааны хувь	90.52%

Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга Рандолф Коппа: Ингээд, тооллогын комиссын өгсөн ирцийн мэдээгээр саналын эрхтэй хувьцааны 90.52% нь ирсэн байх тул үүгээр Худалдаа, хөгжлийн банк хувьцаат компанийн анхны хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц бүрдсэн байна гэж үзлээ. Ийнхүү, хурлын ирц бүрдсэн тул хувьцаа эзэмшигчдийн хурлыг албан ёсоор нээснийг мэдэгдэж байна.

Өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар дэлгэцэн дээр үзүүлж буй гурван асуудлын талаар хэлэлцүүлэн шийдвэрлэх ба хурлыг та бүхэнд хүргүүлсэн саналын хуудасны хамт хүргүүлсэн хурлын дэгийн дагуу хуралдуулах болно. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар:

- 1 дүгээрт, Худалдаа, хөгжлийн банк хувьцаат компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тогтоох тухай;
- 2 дугаарт, Худалдаа, хөгжлийн банк хувьцаат компанийн дүрмийг батлах тухай;
- 3 дугаарт, Худалдаа, хөгжлийн банк хувьцаат компанийн ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай асуудлуудыг хэлэлцэнэ.

Ингээд банкны танилцуулгыг хийнэ үү гэж Худалдаа, хөгжлийн банкны Гүйцэтгэх захирал О.Орхон таныг урьж байна.

Гүйцэтгэх захирал О.Орхон: Сайн байцгаана уу? Эрхэм хүндэт Худалдаа, хөгжлийн банк хувьцаат компанийн хувьцаа эзэмшигч та бүгдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Түрүүн дурдсанчлан манай банк Монголын хөрөнгийн бирж дээр хувьцаагаа олон нийтэд нээлттэй арилжиж хувьцаат компани болсон анхны ээлжит бус хувьцаа эзэмшигчдийн хурал болж байна. Ингээд, та бүхэнд 2023 оны эхний хагас жилийн байдлаар банк хэрхэн санхүүгийн болон бусад үйл ажиллагааны үр дүнтэй ажиллаж байгаа талаар товчхон мэдээлэл өгөхийг хүсэж байна. Арилжааны ууган банк болохын хувьд бид зөвхөн банкныхаа салбарт төдийгүй цаашлаад Монгол Улсынхаа хөгжил цэцэглэлтэд хувь нэмэр оруулах, дэвшил бүхний анхдагч нь байх алсын хараатайгаар үйл ажиллагаагаа явуулж өдгөө 33 дахь жилийнхээ нүүрийг үзээд байна. Бид өнгөрсөн 30 жилийн хугацаанд хөгжилд тэмүүлсэн стратегийн чиглэлийн хүрээнд тогтвортой хөгжилд хамтдаа зорьж ажиллаж байна. Үүнээс гадна бид урт хугацаандаа харилцагч төвтэй банк болох, олон улсын банк болох, платформ банк болох гэсэн зорилгуудыг тавин ажиллаж байна. Эдгээр зорилгуудыг хэрэгжүүлэхдээ бид “Бүтээгч” гэсэн үнэт зүйлээ баримтлан биелүүлэн ажиллаж байна. Англиар бол “Creator” гэж байгаа. Энэ нь бид харилцагч төвтэй, үнэлэмжтэй, төгс төгөлдөр, эгнэгт нээлттэй, эвсэг баг хамт олонтой, гүйцэтгэл төгс, чин хүндлэлтэй ажиллах болно гэж өөрсдийгөө тодорхойлсон байгаа.

Манай банк 2022 оны байдлаар нийтдээ 84 салбар тооцооны төвтэй Япон улсад нэг төлөөлөгчийн газартай үйл ажиллагаа явуулж байна. Нийт 2179 Ти Ди Би-чүүд бид өөрсдийн бүтээгдэхүүн үйлчилгээг томоохон байгууллагууд, жижиг дунд бизнес, иргэдийн сегментийн нийт сая гаруй харилцагч нарт хүргэж, тэдгээрийг хүсэл тэмүүлэлдээ хүрэхэд нь хүлээлтээс нь давсан цогц үйлчилгээг дэвшилтэт технологиор дамжуулан санал болгож байна. Өнөөдөр бид банк санхүүгийн салбарын томоохон тоглогч болохын хувьд банкны системийн активын 21%-ийг дангаараа бүрдүүлж, зах зээлийнхээ 2 дахь том банк болон ажиллаж байна. Хувьцаа эзэмшигчдийн бүтцийн хувьд та бүхэн дэлгэц дээр харж байна. Өнгөрсөн 5 сарын 23-ны өдөр бид нар олон нийтэд 5%-иа арилжаалснаар өмнөх болон одоо нийтийн эзэмшиж байгаа хувьтайгаа нийлээд 6.4%-ийг олон нийт эзэмшиж байна. Голдмэн Сакс Групп 3.12%, Globull Investment and Development Pte. Ltd 60.8%, Ти Ди Би Капитал ХХК 30% гэсэн хувьцаа эзэмшигчдийн бүтэцтэй болж байна.

Санхүүгийн голлох үзүүлэлтүүдийн хувьд 2023 оны хагас жилийн байдлаар нийт актив маань 9.8 их наяд төгрөгт хүрсэн байгаа. Активын өгөөжийн хувьд 1.9%-тай, бид нарын зорьсон 2% гэсэн зорилтот түвшинд явж байна. Өөрийн хөрөнгө маань өмнөх оны эцэстэй харьцуулахад 7 орчим хувиар нэмэгдэж одоо 1.3 их наяд төгрөгт хүрсэн. Энэ нь нийт банкны системийн 24%-ийг дангаараа бүрдүүлж байна. Харин өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтийн хувьд Монголын төв банкны хамгийн доод талын шаардлага болох 13%-иас дээш буюу 17.2 %-тай, өнгөрсөн жилтэй харьцуулахад нилээд нэмэгдсэн байгааг та бүгд харж байна. Банкны ашгийн хувьд 2 дугаар улирлын байдлаар 92.1 тэрбум төгрөгийн ашигтай ажиллаж байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 20%-иар өссөн үзүүлэлт байна. Банкны өөрийн хөрөнгийн өгөөж 15 орчим хувьтай байна. Зах зээлд эзлэх хувь 2023 оны 5 дугаар сарын байдлаар банкны актив, өр төлбөр, зээл, харилцах, хадгаламжаараа зах зээлийн 20-22%-ыг бүрдүүлж байна. Тус бүрийн үзүүлэлтүүд маань дэлгэцэн дээр харагдаж байна. Голлох тэргүүлэх үзүүлэлтүүдийн хувьд Монгол Улсын хэмжээнд нийт байгууллагын зах зээлд олгосон зээлийн 42%-ыг, байгууллагын харилцах, хадгаламжийн 29%-ийг тус тус дангаараа бүрдүүлж байна. Та бүхний харж байгаачлан худалдааны санхүүжилтийн зах зээлд МУ-ын гадаад баталгааны тоогоороо 26%-ийг, дүнгээрээ бол 57%-ийг эзэлж байна. Харин Свифтээр хийгдэж байгаа гадаад төлбөр тооцооны зах зээлийн эзлэх хувь 29-32%-тай ажиллаж байна.

2023 онд эхний хагас жилд хийгдсэн онцлох ажлуудыг та бүхэндээ дурдъя. Бритто картыг зах зээлд амжилттай нэвтрүүлэн ажиллаж байгааг та бүгд мэдэж байгаа байх. Бид нар Бритто системийг амжилттай цогцлоож, цар хүрээгээ улам их тэлсээр байна. Хуримтлалтай Монгол аяныг 3 дахь жилдээ амжилттай үргэлжлүүлж байна. Иргэдийн санхүүгийн боловсролыг дэмжихээс гадна харилцах, хадгаламжийн зах зээлд эзлэх хувь хэмжээгээ өсгөх ажилд бодитой хувь нэмэр оруулж байгаа. Энэ жил бид хялбар хуримтлалын гурван бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлээд амжилттай явж байна. Оны эхэнд ажилтнуудын цалинг 25%-иар өсгөсөн, анхны цаасгүй бүрэн цахимжсан салбарыг нээн ажиллуулж байна. Мөн бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн санхүүгийн хөтөлбөрийг дэмжин ажиллаж байна. Монгол Улсын Trade Finance форумыг амжилттай зохион байгуулсныг та бүгд сайн мэдэж байгаа. Голомт банк, Төрийн банкттай хамтарч АТМ-ийн сүлжээг хамтдаа дундаа ашиглаж, шимтгэлийг хамгийн доод түвшинд бууруулж тавьсан байгаа. Мөн топ 100 аж ахуй нэгжүүдээс бид нар зургаа дугаар байранд бичигдэж, ашгийн хэмжээгээрээ хоёрт эрэмбэлэгдэж, нийт өөрийн хөрөнгийн хэмжээгээрээ дөрөв дүгээрт эрэмбэлэгдлээ. Аз жаргалтай үйлчлүүлэгч буюу хүлээлтээс давсан үйлчилгээ болон чанарын менежментийн тогтолцоо буюу хэрэглэгчийн сэтгэл ханамжийг үргэлж дээшлүүлэх стандартуудыг Монголдоо бас анхлан нэвтрүүллээ. Хоёр долоо хоногийн өмнө Монгол Улсад тогтвортой санхүүжилтийн долоо хоног гэсэн том арга хэмжээг бид хамтдаа зохион байгуулсан бөгөөд манай банкны хувьд 2022 он, 2023 онд тус хөтөлбөрийн манлай банкаар ажиллаж байгаа. Ингээд ногоон санхүүгийн олон улсын манлайллын хөтөлбөр гэдэг том арга хэмжээ, форумыг Монгол улсдаа зохион байгуулж нийтдээ 25 гаруй улсаас төлөөлөгчид ирж оролцсон байгаа.

Өнгөрсөн долоо хоногт миний бие БНХАУ-ын Тьянжин хотод очиж зуны Давос хэмээх арга хэмжээнд оролцлоо. Арга хэмжээний хүрээнд бид нар Монгол Улсаас анх удаагаа Дэлхийн эдийн засгийн форум байгууллагын албан ёсны түнш байгууллага болж, Ноён Клаус Швабтай миний бие хамтарч гэрээ зурсан.

Мөн энэ хугацаанд бид нар Bank of China-тай стратегийн хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурсан. Хятад улсын ICBC стандарт банкттай тодорхой хэмжээний олон улсын гүйлгээ, олон улсын арилжаа, урт хугацаат своп арилжаа зэрэг олон улсын төлбөр тооцоо, арилжааны гэрээг үзэглээд байна. Түүнчлэн, өнгөрсөн 6 сард АНУ-ын банк нь Монгол Улсад ирсэн бөгөөд манай банканд дээр хийж байгаа due diligence ажлыг албан ёсоор хийж дуусгаснаар бид АНУ-ын банканд дээр шууд Ностро данс нээх анхны арилжааны банк болох ийм болзлоо хангасан байгаа. Байгууллага, иргэддээ зориулсан цоо шинэ бүтээгдэхүүнүүдийг нэвтрүүлсэн хэвээр байна. Хамгийн эхний ээлжид гадаад худалдааны тээврийн санхүүжилтийн зээлийн эрхийн бүтээгдэхүүнийг нэвтрүүллээ. Байгууллагын зарлага гаргах эрхтэй хадгаламжийн шинэ бүтээгдэхүүнийг нэвтрүүллээ. Тендерийн гэрээ барьцаалсан зээлийн бүтээгдэхүүн, сүлжээ дэлгүүрүүдийн авлага барьцаалсан зээлийн эрхийн бүтээгдэхүүн, ПОС машин ашиглахгүй андройд утсан дээр шууд төлбөр хүлээн авах боломжтой Софт ПОС төлбөрийн цоо шинэ шийдлийг нэвтрүүллээ. VIP болон Premiere харилцагчиддаа зориулсан Платинум багц бүтээгдэхүүнүүдийг мөн шинээр нэвтрүүлээд байна. Товчхондоо Худалдаа, хөгжлийн банк хувьцаат банк нь 2023 оны эхний хагас жилийн байдлаар эдгээр үр дүн болон санхүүгийн үзүүлэлттэйгээр ажиллаж байна.

Худалдаа, хөгжлийн банкны дүрмийн төслийг танилцуулъя.

Худалдаа, хөгжлийн банк нь нээлттэй хувьцаат компани болсонтой холбоотойгоор банкны дүрэмд шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулах хуулийн шаардлага бий. Дүрэмд орж байгаа нэмэлт, өөрчлөлтүүдийг та бүгдэд дэлгэрэнгүй урьдчилан тараасан учраас гол орж байгаа өөрчлөлтүүдийг товчхон танилцуулъя. Шаардлагын хувьд компанийн хэлбэрийг өөрчилж байгаа учраас хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд дүрмийн өөрчлөлтийг танилцуулж, хувьцаат компани хэлбэрээр үйл ажиллагаа явуулахад шаардлагатай өөрчлөлтүүдийг тусган шинэчлэн батлуулах шаардлага үүссэн. Товчхондоо энэ дүрмээр банк хувьцаат компани болох болзол шаардлагыг хангасан, хувьцаат компани болсноо зайлшгүй тусгах үе шат гэж ойлгож болно. Хувьцаат компани болсноор банк зөвхөн Монголбанкны төдийгүй Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “СЗХ” гэх)-ны зохицуулалтуудад харьяалагдаж, ил тод тайлагналын үүргүүдийг хүлээх, ХЭХ-ыг зарлан хуралдуулах процессыг шинэчлэх, ногдол ашиг хуваарилахтай холбоотой шинэ дүрэм журмыг мөрдөх, ТУЗ, түүний хороод гүйцэтгэх удирдлагын эрх хэмжээг илүү дэлгэрэнгүй тодорхойлох зэрэг зарчмын өөрчлөлтүүдийг оруулж байна.

Дүрмийн төслийг IPO ажлын хэсгийн хүрээнд банкны холбогдох ажлын хэсгээс боловсруулсан. Дотооддоо санал авч, хөндлөнгийн хуулийн фирмээр хянуулж, СЗХ-нд урьдчилан танилцуулж, уг дүрмийн төслийг Монгол Улсад хэрэгжиж байгаа хууль тогтоомж, СЗХ-ны дүрэм журам энэ бүх зохицуулалтад нийцүүлсэн ба холбогдох урьдчилсан зөвшөөрлийг авсны үндсэн дээр та бүгддээ танилцуулж байна. Компанийн хэлбэрийг өөрчилсөнтэй холбоотой банкны бүтэн нэр Худалдаа, хөгжлийн банк хувьцаат компани, англи хэл дээр Trade and Development bank Joint stock company болж байгаа. Банк СЗХ-ны хувьцаат компанитай холбоотой зохицуулалтуудыг давхар дагаж мөрдөж эхлэж байгаа бөгөөд холбогдох зохицуулалтуудыг нь мөн тусгаж өгсөн. Хувьцаа нэмж гарган нийтэд санал болгосонтой холбогдуулан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг дараах байдлаар бас өөрчлөн тусгав. Зарласан хувьцааны тоо хэвээрээ, нэг бүр нь 6,736.10 төгрөг байна. Гаргасан хувьцааны тоо нэмэгдэж, шинэ дүрмээр 50,600,927 (тавин сая зургаан зуун мянга есөн зуун хорин долоо) ширхэг энгийн хувьцаа болж байгаа. Хувь нийлүүлсэн хөрөнгийн дүн нэмэгдэж, 340,852,904,364.70 (гурван зуун дөчин тэрбум найман зуун тавин хоёр сая есөн зуун дөрвөн мянга гурван зуун жаран дөрвөн төгрөг, далан мөнгө) төгрөг болж байгаа. Энэхүү дүрмэнд хувьцаа эзэмшигчид хувьцаагаа хуульд заасны дагуу чөлөөтэй захиран зарцуулах, хувьцаа эзэмшигчийн эрх, үүрэгтэй холбоотой зохицуулалтуудыг шинэчлэн оруулсан болно. ХЭХ хуралдуулах болон ногдол ашиг хуваарилахтай холбоотой шинэ зохицуулалтуудыг дүрмэндээ тусгаж өгсөн. Мөн, ТУЗ-ийн бүрэн эрхэд танилцуулгад харагдаж буй дараах бүрэн эрхүүд шинээр нэмэгдсэн байна. Үүнд, Банкны зохистой засаглалын бодлого, журмууд болон Ёс зүйн дүрмийг тогтоож, хэрэгжилтэд хяналт тавих, Банкны нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын тогтолцоо, хөндлөнгийн болон дотоод аудит, эрсдэлийн удирдлага, санхүүгийн болон үйл ажиллагааны хяналт, хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг хамарсан зохистой хяналтын тогтолцоог бүрдүүлэх, хууль тогтоомжид заасны дагуу нийтэд мэдээлэх санхүүгийн тайлан бусад мэдээллийг мэдээлэх явцад хяналт тавих гэсэн ийм эрх, үүргүүд байна. Мөн, одоо хороодын эрх үүргүүдийг Дүрэмдээ тухайлан зааж өгсөн байгаа. Тайлагнал, хязгаарлалтуудтай холбоотойгоор Банкны эрх бүхий албан тушаалтны тоог 100 гаруй байснаас 20 орчим болгож бууруулсан. 2012 онд батлагдаж байсан өмнөх дүрэм нь 18 бүлэг, 140 хэсэг, 3 хавсралтаас бүрдэж байсан бол шинэ дүрэм нь 15 бүлэг, 118 хэсэгтэй, дараах бүрэлдэхүүнтэй дүрэм болж өөрчлөгдөж байна. Энэхүү дүрмийг ХЭХ-аар баталж өгнө үү гэж та бүгдээс хүсэж байна. Дүрэмтэй холбоотой тодорхой асуултууд байвал энэ хуралд миний биеэс гадна манай банкны ТУЗ-ийн Дарга, Банкны Ерөнхийлөгч, Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч болон бусад Гүйцэтгэх захирлын орлогч нар оролцож байгаа тул тухай бүр хариулах болохыг мэдэгдэхэд таатай байна. Анхаарал хандуулсан Та бүхэндээ баярлалаа.

Хөтлөгч О.Баярсайхан: Баярлалаа. Ингээд Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн дүрмийн төслийг танилцуулж дууссан тул энэхүү асуудалтай холбоотой асуулт, хариултын хэсэг эхэлж байгааг мэдэгдэж байна. Та бүхэнд Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн дүрмийн төслийн танилцуулгатай холбоотой асуулт байвал энэхүү танхимын голд Хувьцаа эзэмшигч нарт зориулсан микрофон байршуулсан хэсэгт очиж, асуулт асуух боломжтой. Эхлээд танхим дахь хувьцаа эзэмшигчид асуулт асууж, хариулт өгсөний дараа цахимаар оролцож буй хувьцаа эзэмшигчдийн асуусан асуултад хариулах болно. Цахимаар оролцож буй хувьцаа эзэмшигч та бүхний зүгээс асуулт байвал Zoom meeting-ийн чат хэсэгт холбогдож, асуултаа ирүүлэхийг хүсэж байна. Баярлалаа.

Танхимаас болон цахимаас асуулт ирээгүй байгаа тул хурлаа үргэлжлүүлэн дараагийн хэлэлцэх асуудалдаа орцгооё. ХХБ-ны ТУЗ-ийн гишүүдэд нэр дэвшигчдийг танилцуулна уу хэмээн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Н.Нямсүрэн таныг урьж байна.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Н.Нямсүрэн: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Банкны тухай хууль, Компанийн тухай хуулийн зохицуулалт, мөн Монголбанкны “Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам”-ын шаардлага хангасан 9 гишүүнийг ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын болон нэр дэвшүүлэх хорооны хурлаар хэлэлцээд, та бүхэнд өнөөдөр томилж өгнө үү гэж танилцуулж байна. Товчхон танилцуулъя. Хараат бус гишүүдийн танилцуулгаас эхэлье.

Эхний гишүүн Ж.Болормаа. ОХУ, Иванова хотын Нэхмэлийн Дээд Сургуулийг нэхмэлийн инженер технологичийн мэргэжлээр төгсөж, БНСУ-ын Хандоны Их Сургууль, СЭЗИС-ийн хамтарсан хөтөлбөрийг Бизнесийн удирдлагын магистраар дүүргэсэн. Ажлын гараагаа Говь компаниас эхэлснээс хойш Монголын хөрөнгийн бирж, СЗХ-нд газрын ажилтан, газрын даргын албан тушаал

хашсан зэрэг санхүүгийн салбарт олон жил ажилласан туршлагатай гишүүн юм. Манай банкны ТУЗ-ийн хараат бус гишүүнээр 2017 оноос хойш ажилласан ба 35 жилийн ажлын туршлагатай нэр дэвшигч байна.

Дараагийн нэр дэвшигч Ж.Дэлгэрсайхан. ХААИС-ийг Эдийн засагч, СЭЗИС-ийг Санхүүгийн магистр, МУИС-ийн ХЗС-ийг эрх зүйч мэргэжлээр төгссөн. Санхүү эдийн засгийн их сургуульд багш, тэнхимийн эрхлэгч, зөвлөх багшаар 1996 оноос хойш ажиллаж байна. 2017 оноос хойш ХХБ-ны ТУЗ-ийн хараат бус гишүүнээр ажиллаж байна.

Гурав дахь нэр дэвшигч З.Нарантуяа. ОХУ-ын Эрхүү хотын Улсын Их Сургуулийг хуульч, СЭЗИС-ийг эдийн засагч-санхүүч мэргэжлээр төгссөнөөс гадна АНУ, Колумбын Их Сургуулийн Олон Улсын Харилцааны Сургуульд төрийн удирдлагын магистрын зэрэг хамгаалсан. Ажлын гараагаа Монголбанкны хуулийн газар мэргэжилтэн, ахлах мэргэжилтэн, газар, хэлтсийн захирал, захирлын үүрэг гүйцэтгэгч, газрын орлогч даргаар ажиллаж байснаас гадна Монгол Шуудан банк, Хадгаламж банканд ажиллаж байсан туршлагатай. Мөн, 2016 оноос 2020 оны хооронд УИХ-ын гишүүнээр ажиллаж байсан. 2023 оноос ХХБ-ны ТУЗ-ийн хараат бус гишүүнээр ажиллаж байгаа.

ТУЗ-ийн ердийн гишүүнээр 6 хүнийг нэр дэвшүүлж байна.

Эхний гишүүн Рандолф Коппа. Өнөөдрийн энэ ХЭХ-ын дарга ба өнөөдрийн байдлаар ТУЗ-ийн даргаар ажиллаж байна. Рандолф Коппа нь АНУ-ын Висконсин мужийн Мэдисоны Их Сургуулийг Олон улсын харилцааны мэргэжлээр төгссөнөөс хойш зөвхөн Америкийн төдийгүй дэлхийн 12 орны банк, санхүүгийн байгууллагад удирдах ажил хашиж ирсэн туршлагатай. Монгол Улсад буюу манай банканд 2003 оноос хойш ажиллаж байгаа. 2016 оноос ТУЗ-ийн гүйцэтгэх дэд даргаар, 2022 оноос ТУЗ-ийн даргаар ажиллаж байна.

Дараагийн нэр дэвшигч Д.Эрдэнэбилэг. МУИС-ийг эрх зүйч мэргэжлээр, Монгол Улсын Удирдлагын Академийг улс төр судлалын магистр, СЭЗИС-ийг Банк санхүүгийн мэргэжлээр тус тус төгссөн. Улаанбаатар хотын банк болон ХХБ-ны ТУЗ-ийн гишүүн, даргаар ажиллаж байсан туршлагатай.

Гурав дахь ердийн гишүүнд нэр дэвшигч Д.Хүрэлбаатар. Худалдааны техникумыг нягтлан бодогч мэргэжлээр төгссөн. Үүний дараа ОХУ-ын Эрхүү хотын Улс Ардын Аж Ахуйн Дээд Сургуулийг Банкны эдийн засагч мэргэжлээр төгссөн. 1981 оноос эхлэн тэр үеийн нэрээр Улсын банкны ерөнхий хорооны Хяналт шалгалтын газарт улсын байцаагчаар ажлын гараагаа эхэлсэн ба 1991 оноос ХХБ-нд харилцагчийн үйлчилгээний чиглэлээр түлхүү ажилласан буюу газар, хэлтсийн захирлаар ажиллаж байсан. Үүний дараа Монгол шуудан банканд Дэд захирлаар ажилласан. ХХБ-нд 2007-оос 2020 он хүртэл Гүйцэтгэх захирлын орлогчоор ажиллаж байгаад 2020 оноос ТУЗ-ийн гишүүнээр томилогдон ажиллаж байгаа.

Дөрөв дэх нэр дэвшигч Д.Янжмаа. Санхүүгийн техникум болон МУИС-ийг банкны нягтлан бодогч, эдийн засагч мэргэжлээр төгссөн. Өмнөх нэр дэвшигчийн адил Улсын банкны ерөнхий хороонд нягтлан бодогч, ахлах нягтлан бодогчоор ажлын гараагаа эхэлснээс хойш ХХБ, Монгол шуудан банк, Капитрон банкны Санхүүгийн газар, Санхүүгийн удирдлагын газрын захирлаар олон жил ажилласан. Өөрөөр хэлбэл, 45 гаруй жилийн ажлын туршлагатай, энэ салбарын туршлагатай ажилтны нэг байна. 2019 оноос одоог хүртэл ХХБ-ны ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байна.

Дараагийн нэр дэвшигч А.Энхмэнд. ШУТИС-ийг инженер, технологич мэргэжлээр бакалавр, магистрын зэрэгтэй төгссөн. СЭЗИС-ийг нягтлан бодогч- эдийн засагчийн мэргэжлээр төгссөн. 2004 оноос Интер банк, Улаанбаатар хотын банк, ХХБ-нд Дэд захирал, Гүйцэтгэх захирлын орлогч, Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч, Гүйцэтгэх захирлаар тус тус ажиллаж байгаа туршлагатай боловсон хүчний нэг байна.

Ердийн гишүүнд нэр дэвшүүлж буй сүүлийн нэр дэвшигч Д.Отгонбилэг. Монгол Улсын Их Сургуулийг эдийн засагч мэргэжлээр төгссөн. Мөн сургуульдаа бизнесийн удирдлагын магистрын зэрэг хамгаалсан. 1997 оноос Сэргээн босголт банк, Хадгаламж банк, Интер банк, Улаанбаатар хотын банк болон ХХБ-д харилцагчийн үйлчилгээний хэлтэст нягтлан бодогч, Дотоод аудитын газарт ажилтан, ахлах ажилтан, Дотоод аудитын газрын захирал, Эрсдэлийн удирдлагын газрын

захирал, Эрсдэлийн удирдлага хариуцсан Гүйцэтгэх захирлын орлогчоор тус тус ажиллаж байгаад 2021 оноос МИК ОССК ХХК-д Дэд захирлын албан тушаал хашиж байгаа нэр дэвшигч байна.

Ингээд та бүхэнд ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигч 3, ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигч 6 нэр дэвшигчдийн товч танилцуулгыг танилцууллаа. Та бүхэнд асуух зүйл байвал хариулъя аа. Баярлалаа.

Хөтлөгч О.Баярсайхан: Ингээд ХХБ-ны ТУЗ-ийн гишүүдэд нэр дэвшигчдийг танилцуулж дууссан тул энэхүү асуудалтай холбоотой асуулт хариултын хэсэг эхэлж байна. Та бүхэнд ХХБ-ны ТУЗ-ийн гишүүдэд нэр дэвшигчтэй холбоотой асуулт байвал танхим дахь хувьцаа эзэмшигчид өмнөхийн адил танхимын голд байрлуулсан микрофон дээр очиж, цахимаар оролцож буй хувьцаа эзэмшигч та бүхэн ZOOM чатаар асуултаа ирүүлэхийг хүсэж байна. Өмнөх асуулт, хариулт хэсэгтэй адилаар Банкны зүгээс эхлээд танхим дахь хувьцаа эзэмшигчдийн асуултад хариулт өгсний дараа цахимаар асуултаа ирүүлсэн хувьцаа эзэмшигчдийн асуултад хариулах болно.

Хувьцаа эзэмшигч Ж.Энх-Амгалан: Өдрийн мэнд хүргэе. Сайн байцгаана уу. Хувьцаа эзэмшигч болоод хувьцаа эзэмшигчдийнхээ хуралд оролцож байгаадаа баяртай байна. Хувьцаа эзэмшигч Энх-Амгалан байна. Асуулт товчхон. Нэр дэвшиж байгаа гишүүдийн хувьд саналгүй. Бүгдийг нь дэмжиж байгаа. Мундаг, чадвартай, танигдсан улсууд дэвшиж байгаа гэж бодож байгаа. Харин дүрмийн төслийг уншиж байхад аудитын хорооных нь чиг үүрэг дээр банкны дотоод хяналтын албаны удирдлагыг томилох гээд “хяналтын” гэдэг үг явж байгаа нь нэр томьёоны хувьд буруу юм шиг санагдаж байгаагаа хэлье. ТУЗ-ийн эрх, үүрэг хэсэгт бол дотоод аудит гэдэг нэршлээр байна лээ. Аудитын хорооны эрх, үүрэг хэсэгт дотоод хяналтын нэгжийн удирдлагыг томилох чөлөөлөх гээд Гүйцэтгэх удирдлагын хариуцах чиг үүргийг Аудитын хороонд оруулчихсан юм шиг тэгж ойлгож байгаа. Нэр томьёоны нэг санал байна. ТУЗ-ийн гишүүдээр нэр дэвшиж байгаа нэр дэвшигчдийн мэдээлэлтэй банкны цахим сайтаас танилцсан. Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч ТУЗ-ийн гишүүн маань Аудитын хорооны гишүүн гээд томилогдчихсон байна лээ. Тэрийг дотоод аудитын стандарт, олон улсын стандарт, сайн засаглалын талаасаа буруу гэж үзэж байна. Дотоод аудитынхаа нэгжийн хараат бус байдалд буруугаар нөлөөлдөг. Өөрийнх нь нэгжүүдийг шалгах бол хараат бус байдал алдагдана. Ийм саналтай байна. Энэ дээр та бүхэн тэгээд тайлбар хэлнэ үү? Өөр саналгүй ээ. Баярлалаа.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Н.Нямсүрэн: Хууль, эрх зүй хариуцсан Гүйцэтгэх захирлын орлогч бусад асуултад хариулна. Миний бие Аудитын хороотой холбоотой хамгийн сүүлийн асуултад нь эхлээд хариулт өгье. Өнөөдрийн хурлаар ТУЗ-ийн гишүүдээ сонгосны дараа ТУЗ-ийн гишүүд маань даргаа дахиж сонгоно. Үүний дараа ТУЗ-ийн дэргэдэх хороодийн бүрэлдэхүүнээ дахин сонгоно. Түрүүн Орхон захирал маань дүрмийн танилцуулга дээр хэлсэн. Бид өмнө нь ХХК байхад голчлон Банкны тухай хуулиар зохицуулагдаж байсан. Зохицуулагч байгууллага маань Монголбанк байсан бол одоо хувьцаат компани болохоор СЗХ, Монголын хөрөнгийн бирж зэрэг зохицуулагч байгууллагын тоо нэмэгдэж, зохистой засаглалын кодексыг зайлшгүй хэрэгжүүлэх үүрэгтэй болж байгаа. Үүний дагуу ТУЗ-ийн дэргэдэх 3 хороодийн дарга нь хараат бус гишүүн байна. ТУЗ-ийн дэргэдэх хороодын гишүүдийн 2/3 нь хараат бус гишүүд байна. Энэ хурлын дараа ТУЗ-ийн дарга, хороодын бүрэлдэхүүн дахин сонгох үеэр СЗХ-оос тавьж байгаа шаардлага, холбогдох хууль тогтоомжийн дагуу хороодын бүрэлдэхүүн дахин өөрчлөгдөнө. Үүний дагуу Энх-Амгалан хувь нийлүүлэгчийн санал хэлж буй асуудал шийдэгдэнэ.

Гүйцэтгэх захирлын орлогч Ц.Ганбаяр: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. ХХБ-ны Хууль, эрх зүй хариуцсан Гүйцэтгэх захирлын орлогч Ц.Ганбаяр байна. Энх-Амгалан хувьцаа эзэмшигчийн асуултад хариулъя. Энх-Амгалан хувьцаа эзэмшигч нь өөрөө мэргэшсэн аудитор болохоор аудитын талаасаа дүрмийн төсөлд найруулгын санал өгч байх шиг байна. Тэгэхээр одоо дүрмийн төсөл нэгэнт тараагдсан байгаа учраас та бүхэн саналаа өгөөд биччихэж болно. Санал нь үг сонголт, найруулгын шинжтэй буюу зарчмын шинжтэй санал биш байна. Тэгэхээр хувьцаа эзэмшигч та саналын хуудас дээр саналаа өгөөд үлдээгээрэй.

Хөтлөгч О.Баярсайхан: Манай хувьцаа эзэмшигчдийн зүгээс өөр асуух асуулт байгаа болов уу? Хэлэлцэх асуудалтай холбоотой танхимаас болон цахимаар ирсэн өөр асуултууд байхгүй байгаа тул дараагийн хэсэг рүүгээ шилжее.

Ингээд ХЭХ-аас гарах тогтоолын төслүүдийг танилцуулна уу гэж ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Н.Нямсүрэн таныг урьж байна.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Н.Нямсүрэн: Өнөөдрийн ХЭХ-аас гурван тогтоол гарна. Та бүхэнд эхний тогтоолыг танилцуулъя.

**ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН БАНК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

___ оны ___ сарын ___ өдөр

Дугаар ___

Улаанбаатар хот

Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх тухай

Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2.2 дахь заалт, 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.15, 62.1.16 дахь заалт, Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.2 дахь заалт, “Худалдаа, хөгжлийн банкны дүрэм”-ийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.3 дахь хэсэг, 7.4.13, 7.4.14 дэх заалт болон Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн Худалдаа, хөгжлийн банкны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас ТОГТООХ нь:

1. Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн энгийн хувьцааны нэг бүрийн нэрлэсэн үнийг 6,736.10 (зургаан мянга долоон зуун гучин зургаан төгрөг, арван мөнгө) төгрөг, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 340,852,904,364.70 (гурван зуун дөчин тэрбум найман зуун тавин хоёр сая есөн зуун дөрвөн мянга гурван зуун жаран дөрвөн төгрөг, далан мөнгө) төгрөгөөр тус тус тогтоосугай.
2. Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас гарсан тогтоолыг холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлж, нээлттэй ил тод мэдээллийг хувьцаа эзэмшигчдэд хүргэж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга (Н.Нямсүрэн)-д үүрэг болгосугай

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА

РАНДОЛФ КОППА

ХУРЛЫН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Н.НЯМСҮРЭН

Дараагийн 2 дахь тогтоолын төсөл:

**ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН БАНК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

___ оны ___ сарын ___ өдөр

Дугаар ___

Улаанбаатар хот

Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн дүрэм батлах тухай

Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.1 дэх заалт, “Худалдаа, хөгжлийн банкны дүрэм”-ийн 7 дугаар зүйлийн 7.4.1 дэх заалт болон Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн Худалдаа, хөгжлийн банкны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас ТОГТООХ нь:

1. “Худалдаа, хөгжлийн банк хувьцаат компанийн дүрэм”-ийг энэхүү тогтоолын Хавсралт 1-ийн дагуу баталсугай.
2. “Худалдаа, хөгжлийн банк хувьцаат компанийн дүрэм”-ийг холбогдох төрийн эрх бүхий байгууллагуудад зохих журмын дагуу бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал (О.Орхон)-д даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА

РАНДОЛФ КОППА

ХУРЛЫН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Н.НЯМСҮРЭН

3 дахь тогтоол дахь ТУЗ-ийн гишүүдийг өнөөдрийн хурлаас сонгон, баталгаажуулах тул ХЭХ-ын тогтоолд нэр тусгахгүйгээр танилцуулж байна.

ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН БАНК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

___ оны ___ сарын ___ өдөр

Дугаар ___

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, 77 дугаар зүйлийн 77.2 дахь хэсэг, Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.8 дахь заалт, 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэг болон “Худалдаа, хөгжлийн банкны дүрэм”-ийн 7 дугаар зүйлийн 7.4.5 дахь заалт болон Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн Худалдаа, хөгжлийн банкны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас ТОГТООХ нь:

1. Дараах нэр дэвшигчдийг Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр сонгосугай.
 - 1.1.
 - 1.2.
 - 1.3.
2. Дараах нэр дэвшигчдийг Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр сонгосугай.
 - 2.1.
 - 2.2.
 - 2.3.
 - 2.4.
 - 2.5.
 - 2.6.
3. Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Компанийн засаглалын кодекс болон бусад хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын дүрэм, журам, заавар, Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн дүрэм, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам болон бусад шаардлагатай дүрэм, журам, зааврыг чанд баримтлан ёс зүйтэй, хариуцлагатай ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН

ХУРЛЫН ДАРГА

РАНДОЛФ КОППА

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Н.НЯМСҮРЭН

Санал хураалт дуусаж тооллогын дүн гарсаны дараа хараат бус болон ердийн гишүүнээр сонгогдсон нэр дэвшигчдийн нэр энэ тогтоолын төсөлд эцэслэн тусгагдана. Энэхүү 3 тогтоолыг өнөөдөр бид нар хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж, хувьцаа эзэмшигчдийн саналын дагуу батлах болно. Баярлалаа.

Хөтлөгч О.Баярсайхан: Баярлалаа. Ийнхүү ХЭХ-аар хэлэлцэх асуудлууд болон тогтоолын төслүүдээ танилцуулж дууссан тул санал хураалтыг албан ёсоор эхлүүлж байна. Та бүхэнд санал хураалттай холбоотой зөвлөгөө видеог одоо хүргүүлэх ба видео танилцуулгын дараа та бүхний хувьд санал хураалтын үе шат 10 минут үргэлжлэхээр байна. Та бүхэн саналын хуудсаа тус хугацаанд багтаан бөглөж танхимын хойд хэсэгт байрлах тооллогын комиссын гишүүдэд хүлээлгэн өгөхийг хүсэж байна.

[Саналын хуудас бөглөх видео зааварчилгаа дэлгэцээр танилцуулав.]

Хөтлөгч О.Баярсайхан: Санал хураалтын хугацаа дуусаж, тооллогын комисс санал хураалтын дүнг нэгтгэн гаргаж дуустал хугацаанд та бүхнийг хурлын танхимын нөгөө талд байрлах танхимд цайны завсарлагад оролцохыг урьж байна. Тооллогын комиссийн дүн гарч дуусмагц та бүхэнд мэдэгдэх болно. Баярлалаа.

Хөтлөгч О.Баярсайхан: Хүндэт хувьцаа эзэмшигчид хөрөнгө оруулагчид аа. ХХБ-ны 2023 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн ээлжит бус хурлын санал хураалтын үр дүн гарсан байна. Иймд санал хураалтын үр дүн болон ХЭХ-ын шийдвэрүүдийн талаар танилцуулна уу хэмээн Хурлын дарга Рандолф Коппа болон тооллогын комиссын дарга Л.Одмаа нарыг урьж байна.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга Рандолф Коппа: Тооллогын комиссын даргын нэгтгэлийг хүлээж байгаа тул та бүхэн түр хүлээж байхыг хүсэе.

Ингээд хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын санал хураалтын дүнг танилцуулна уу хэмээн тооллогын комиссын дарга Л.Одмааг урьж байна.

Тооллогын комиссын дарга Л.Одмаа: Сайн байцгаана уу? Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Тооллогын комиссын шийдвэрийг танилцуулъя.

**“ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН БАНК” ХК-ийн ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ШИЙДВЭР**

2023 оны 07 дугаар сарын
07-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Санал хураах хуудсыг тоолсон тооллогын дүнгийн тухай

Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.2, 67.3.6, 67.3.8 дахь заалт, 67.4 дэх хэсэг, 72 дугаар зүйл, “Худалдаа, хөгжлийн банк” ХХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.20.2, 7.20.4, 7.20.5 дахь заалт болон Худалдаа, хөгжлийн банкны хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд цахимаар болон цаасаар ирүүлсэн саналын эрхийг тоолсон тооллогын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Худалдаа, хөгжлийн банк” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцсэн “Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тогтоох тухай” асуудалд хурлаас гарах шийдвэр болон түүний төсөлд хувьцаа эзэмшигчдээс өгсөн саналыг тоолсон тооллогын дүнг доор дурдсанаар баталсугай.

Тооллогын дүн:

Зөвшөөрсөн 45,810,937 ширхэг хувьцаа буюу 99.80455 хувь;

Татгалзсан 0 ширхэг хувьцаа буюу 0 хувь;

Түдгэлзсэн 0 ширхэг хувьцаа буюу 0 хувь.

2. “Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тогтоох тухай” асуудалд өгсөн саналыг тоолоход нийт 0 ширхэг хувьцаа буюу 0 хувьд эзлэх хүчингүй саналын хуудас байсныг дурдсугай.

3. Шийдвэрийн 1 болон 2 дугаар зүйлд заасан тооллогын дүнг Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд танилцуулахыг Тооллогын комиссын дарга (Л.Одмаа)-д үүрэг болгосугай.

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА

Л.ОДМАА

Дараагийн шийдвэрийг танилцуулъя.

**“ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН БАНК”-ийн ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ШИЙДВЭР**

2023 оны 07 дугаар сарын
07-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Санал хураах хуудсыг тоолсон тооллогын дүнгийн тухай

Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.2, 67.3.6, 67.3.8 дахь заалт, 67.4 дэх хэсэг, 72 дугаар зүйл, “Худалдаа, хөгжлийн банк” ХХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.20.2 дахь заалт, 7.20.4 дэх заалт, 7.20.5 дахь заалт болон Худалдаа, хөгжлийн банкны хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд цахимаар болон цаасаар ирүүлсэн саналын эрхийг тоолсон тооллогын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Худалдаа, хөгжлийн банк” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцсэн “Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн дүрэм батлах тухай” асуудалд хурлаас гарах шийдвэр болон түүний төсөлд хувьцаа эзэмшигчдээс өгсөн саналыг тоолсон тооллогын дүнг доор дурдсанаар баталсугай.

Тооллогын дүн:

Зөвшөөрсөн 45,810,937 ширхэг хувьцаа буюу 99.80455 хувь;

Татгалзсан 0 ширхэг хувьцаа буюу 0 хувь;

Түдгэлзсэн 0 ширхэг хувьцаа буюу 0 хувь.

2. “Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн дүрэм батлах тухай” асуудалд өгсөн саналыг тоолоход нийт 0 ширхэг хувьцаа буюу 0 хувьд эзлэх хүчингүй саналын хуудас байсныг дурдсугай.

3. Шийдвэрийн 1 болон 2 дугаар зүйлд заасан тооллогын дүнг Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд танилцуулахыг Тооллогын комиссын дарга (Л.Одмаа)-д үүрэг болгосугай.

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА

Л.ОДМАА

**“ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН БАНК” ХК-ийн ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ШИЙДВЭР**

2023 оны 07 дугаар сарын
07-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Санал хураах хуудсыг тоолсон тооллогын дүнгийн тухай

Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.2, 67.3.6, 67.3.8 дахь заалт, 67.4 дэх хэсэг, 72 дугаар зүйл, “Худалдаа, хөгжлийн банк” ХХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.20.2 дахь заалт, 7.20.4 дэх заалт, 7.20.5 дахь заалт болон Худалдаа, хөгжлийн банкны хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд цахимаар болон цаасаар ирүүлсэн саналын эрхийг тоолсон тооллогын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Худалдаа, хөгжлийн банк” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцсэн “Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай” асуудалд хурлаас гарах шийдвэр болон түүний төсөлд хувьцаа эзэмшигчдээс өгсөн саналыг тоолсон тооллогын дүнг доор дурдсанаар баталсугай.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд нэр дэвшигчдэд өгсөн саналын эрхийг тоолсон тооллогын дүн:

Ж.Болормаа:	Кумулятив саналын тоо 45,810,974.60 байна.
Ж.Дэлгэрсайхан:	Кумулятив саналын тоо 45,811,185.80 байна.
З.Нарантуяа:	Кумулятив саналын тоо 45,810,999.60 байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнд нэр дэвшигчдэд өгсөн саналын эрхийг тоолсон тооллогын дүн:

Рандолф Коппа:	Кумулятив саналын тоо 45,810,880.00 байна.
Д.Эрдэнэбилэг:	Кумулятив саналын тоо 45,810,699.00 байна.
Д.Хүрэлбаатар:	Кумулятив саналын тоо 45,810,703.00 байна.
Д.Янжмаа:	Кумулятив саналын тоо 45,810,829.00 байна.
А.Энхмэнд:	Кумулятив саналын тоо 45,810,704.00 байна.
Д.Отгонбилэг:	Кумулятив саналын тоо 45,810,794.00 байна.

2. “Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай” асуудалд өгсөн саналыг тоолоход нийт 59 ширхэг хувьцаа буюу 0.0001285 хувьд эзлэх хүчингүй саналын хуудас байсныг дурдсугай.

3. Шийдвэрийн 1 болон 2 дугаар зүйлд заасан тооллогын дүнг Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд танилцуулахыг Тооллогын комиссын дарга (Л.Одмаа)-д үүрэг болгосугай.

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА

Л.ОДМАА

Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга Рандолф Коппа:

Тооллогын комиссын гишүүддээ баярлалаа. Тооллогын комиссын дүнгээр Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тогтоох тухай тогтоолыг 99.8% дэмжсэн, Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн дүрмийн батлах тухай тогтоолыг 99.8% дэмжсэн байна.

Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийн тогтоолыг мөн 90%- аас дээш хувьцаа эзэмшигчид дэмжсэн байна.


Хурлаар хэлэлцэх асуудлуудаа амжилттай хэлэлцэж дууслаа.

Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тогтоох тухай, Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн дүрмийн батлах тухай тогтоолуудыг хуралд санал өгсөн хувьцаа эзэмшигчдийн олонхийн саналаар батлав.

Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч Ж.Дэлгэрсайхан, Ж.Болормаа, З.Нарантуяа нарыг хараат бус гишүүнээр, Р.Коппа, Д.Эрдэнэбилэг, Д.Отгонбилэг, А.Энхмэнд, Д.Янжмаа, Д.Хүрэлбаатар нарыг ердийн гишүүнээр сонгох ХЭХ-ын тогтоолыг батлав.

Хуралд хүрэлцэн ирсэн болон цахимаар оролцож буй хувьцаа эзэмшигч нартаа баярлалаа. Та бүхэн сайхан наадаарай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



РАНДОЛФ КОППА

ХУРЛЫН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



Н.НЯМСҮРЭН